



ТУСГААР ТОГТНОЛ БА ҮНДЭСНИЙ ДАРХЛАА INDEPENDENCE AND NATIONAL IMMUNITY

Шийрэвжамцын Насанбат¹

Shihihutug University, E-mail: nasanbatshiirevdorj33@gmail.com

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

Монгол Улс, монголчууд, ДИУ, олон улсын гэрээ хэлэлцээр, ашиг сонирхол, тусгаар тогтнол, түүх, соёл, уламжлал

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2026, 03 сар
Шинэчилсэн: 2026, 03 сар
Хүлээн зөвшөөрсөн: 2026, 04 сар

Keywords:

Mongolia, Mongolians, international treaty, interests, independence, Republic of China, culture, traditions, history

Article history:

Received March, 2026
Revised March, 2026
Accepted April, 2026

ХУРААНГУЙ

Уг өгүүлдэд Монгол Улс XX зуунд тусгаар тогтнолоо олсон түүх, тусгаар тогтнолын үнэ цэнэ, аливаа улс оршин тогтноход түүх, соёл уламжлал ямар үүрэг гүйцэтгэдэг талаар авч үзнэ.

Abstract:

The article examines the history of Mongolia's declaration of national independence in the 20th century, the importance of its declaration of independence, and the roles of history, culture and traditions in acquiring national independence.

Энэ өгүүлэл [CC BY-NC](#) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Танилцуулга

Монгол Улсын тусгаар тогтнол нь зөвхөн дотоод хүсэл тэмүүлээр бус, олон улсын геополитикийн нөхцөл, их гүрнүүдийн ашиг сонирхол, эх оронч удирдагчдын оновчтой бодлогын үр дүнд бүрэлдэн тогтсон юм. Үүний зэрэгцээ үндэсний хэл, соёл, түүх, уламжлал нь үндэсний дархлааны суурь болж, тусгаар тогтнолыг баталгаажуулах чухал хүчин зүйл болдог. Орчин үед даяаршлын нөлөөнд үндэсний үнэт зүйлс сулрах

¹Үндэсний тагнуулын их сургуулийн ахлах багш, доктор (Ph.D)

эрсдэл нэмэгдэж байгаа тул эх оронч үзэл, түүх соёлоо хамгаалах нь үндэсний аюулгүй байдлын чухал зорилт хэвээр байна.

2. Арга зүй

Судалгаанд түүхэн болон харьцуулсан шинжилгээний аргыг ашиглаж, Монгол Улсын тусгаар тогтнол бүрэлдэн тогтсон үйл явцыг баримт, эх сурвалжид тулгуурлан задлан шинжилсэн. Мөн онолын дүн шинжилгээний аргаар үндэсний дархлааны агуулга, түүний орчин үеийн ач холбогдлыг тодорхойлон дүгнэсэн.

3. Судалгааны үр дүн

Соёлын хувьсгалын үед хятадад ажиллаж амьдарч байгаад Манжуураар дамжин Монголд амьдрахаар ирсэн нэгэн буриад эмэгтэйн дурсамжид, “Улаанбаатарт вокзал дээр буутал эргэн тойрон дандаа монгол хүмүүс байлаа. Тэд чихэнд нэн дотно эерүү монгол хэлээрээ хоорондоо ярилцаж байв. Цагдаа нар нь хүртэл монгол. Энэ бол монголчууд өөрснөө засаг төрөө эрхлэн мэддэг тусгаар тогтносон Монгол улс ажээ” Энэ бол хүүхэд балчир үедээ ээж, аавыгаа даган монголоор дамжин Манжуурт суурьшин, тэндээ хүнтэй сууж, хүүхэдтэй болоод хятадад өрнөсөн соёлын хувьсгалын үеийг туулахдаа хятадуудын өвөр монголчуудад хэрэгжүүлсэн аймшигт дарангуйлал, хүчирхийллийг нүдээр үзэж, биеэр туулан, нөхрөөсөө албан хүчээр салж, цөллөгт явж, монгол хүн болж төрснийхөө төлөө хүнд хэцүү хавчлагыг үзсэн хүний энгийн нэг сэтгэгдэл гайхширал байжээ.

Тусгаар тогтносон, бүрэн эрхт эх оронтой байна гэдгийн үнэ цэнийг хэмжишгүй. XX зууны түүх бол монголын үе үеийн эх орончдын туйлын хүсэл мөрөөдөл болсон тусгаар тогтнолоо олох гэсэн тэмцлийн түүх юм. Үүнд, Богд гэгээн, Ханддорж ван, Сайн ноён хан Намнансүрэн, Бодоо, Данзан, Сүхбаатар, Гэндэн, Амар, Чойбалсан, Цэдэнбал нар дотроо лам, хар, феодал, хөрөнгөтөн, зүүнтэн, баруунтан гэж ялгагдаж байсан ч тэднийг нэгтгэж байсан туйлын хүсэл зорилго нь тухайн үеийн дэлхий ертөнцөд ноёрхож байсан дэг журамд нийцүүлэн², их гүрнүүдийн ая эвд тааруулан, тусгаар тогтнолоо албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж, бүрэн эрхт Монгол улсаа байгуулах явдал байсан бөгөөд үүндээ ч хүрч чадсан юм. Учир юун гэвээс тусгаар тогтноно гэдэг их гүрнүүдийн геополитик, олон улсын тогтсон дэг журам, түүхэн уламжлал, дипломат арга алхам зэрэг маш олон зүйлээс нөхцөлддөг болохоос бага буурай үндэстнүүдийн дан хүсэл зоригоос шалтгаалдаггүй нь тэр үед төдийгүй одоо ч тодорхой байгаа факт юм. Манай ихэнх түүхч судлаачид, “Бид ар, өвөр монгол төдийгүй баргыг оруулж нэгдсэн Монгол улс байгуулах ёстой байсан ч орос хятад хоёрын хуйвалдаанаас болж чадаагүй гэж үзэх нь түгээмэл. Гэтэл бодит байдлыг авч үзэхэд огт өөр дүр зураг харагддаг. Хамгийн анх 1905 оны Орос-Японы дайны дараа байгуулагдсан гэрээний нууц хэсэгт Өвөр Монгол Манжуур Японы, Халх Монгол Хаант Оросын нөлөөний бүс байхаар тогтож, бусад их гүрнүүдээр зөвшөөрүүлжээ. Мөн Дундад Иргэн Улсыг байгуулагдахад

² П.Дэлгэржаргал, Б.Чинзориг, Ж.Болдбаатар. Монгол Улсын түүх. УБ хот. 2017 он. 352 дахь тал.

АНУ шууд хүлээн зөвшөөрч, дараа нь 9 улс оролцсон Вашингтоны тунхаглалаар хятадын нутаг дэвсгэрийг хуучин Манж Чин улсын хил хязгаараар байлгахаар баталгаажуулсан. АНУ хятадад талтай хандсандаа биш газарзүйн нөхцөл байдлаасаа шалтгаалж, шинэ тулгар ДИУ-ын нутаг дэвсгэрээс бусад ойр их гүрнүүд илүү хувь хүртгэхээс сэргийлж, “Би биш бол хэн ч биш” гэсэн дипломат арга хэмжээ авсан хэрэг байв. Ийм нөхцөлд манай үе үеийн эх орончид тусгаар тогтнолоо олж авах цорын ганц баталгаа болсон Хаант Орос хожим нь Зөвлөлт Орос улсыг 3 түшжээ. Ингэхдээ Богдын үед ч Ардын засгийн үед ч үндэс угсаа нэгт монголчуудаа нэгтгэн авах зорилгоосоо 1945 он хүртэл няцаагүй юм. Тухайн үед бид оросыг биш хятадыг бүр японыг түших гэж оролдсон бол ямар нөхцөл байдалд орох байсныг цаг хугацаа нотолдог.

Манж гүрний бүрэлдэхүүнд байсан Шинжаан бас Төвд яагаад тусгаар тогтнож чадаагүй юм бэ гэхэд тэд цаг үеийн аятай таатай боломжийг ашиглаж чадаагүйн дээр тэдэнд өөрийн гэсэн Ханддорж, Намнансүрэн, Чойбалсан, Бодоо, оюун санааны хувьд бүх монголчуудыг нэгтгэн татаж байсан Богд хаан шиг хүн байгаагүй юм. Дээрээс нь тэдэнд монголчууд шиг агуу их түүх соёл, тусгаар тогтнох⁴ сэтгэлгээ дутаж байв. Жишээ нь, Шинжаан дотроо олон үндэстэн ястнаас тогтсон эв нэгдэлгүй, бутархай байсны дээр тусгаар тогтносон түүх уламжлал, сэтгэлгээ байсангүй. Төвөдийн хувьд монголчууд шиг олон улсын тогтсон хууль журамд нийцсэн үйл ажиллагаа явуулж, улсаа албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэхийн оронд “жаахан хүүхэд нүдээ таглаад харагдахаа байлаа” гэж итгэдэг шиг хилээ хааж, бусад улсуудаас харилцаагаа тасалж, нүдэн балай чихэн дүлий суухыг илүүд үзсэн. Уг нь тэдэнд оюун санааны удирдагч Далай лам, түүх уламжлалын хувьд ч Соронзонгомбо хааны үед хүчирхэг төр улс байгуулсан бодит түүх, хятадтай сөргүүлж өөрийн эрх ашгийг оруулах гэсэн Британи, Хаант Орос зэрэг нөлөө бүхий улсуудын ашиг сонирхол байсан авч, монголчууд шиг идэвхтэй тоглолт нүүдэл хийх, мэдрэмж ухаан дутжээ. Энэхүү муйхар бодлогынхоо хор уршгаар тэдний хувь заяа өөрсөдгүйгээр нь шийдэгдэж, 1952 онд ХАЧА-ийн цэрэг орж ирэхэд өмөөрч түших гадна дотнын холбоотонгүй хүчээр автсан байна. Гэтэл монголчууд үйл явдлын өрнөлийг эртнээс тооцож, олон шугамаар тагнуулын мэдээлэл цуглуулж, ДИУ байгуулагдахаас өмнө амжиж тусгаар тогтнолоо зарлаж, дараа жил нь Хаант Оростой гэрээ байгуулж байв.

1912 оны Орос Монголын гэрээний ач холбогдлыг багаар үнэлж болохгүй ээ. Үүгээр бид өөрийн тусгаар тогтнолын асуудлыг ДИУ-ын дотоод асуудал биш олон улсын хэмжээний асуудал болгож чадсан юм. Эх орончдын хэд хэдэн үе тухайлбал, Богд болон түүний шадрууд, ардын намын анхны долоо, баруунтнууд гэгдэх аядуу үзэлтнүүд, зүүнтнүүд гэх хэт хувьсгалчид Амар Гэндэн гэх хүчирхэг хувь хүмүүс эцэст Чойбалсан Цэдэнбалын үед л олж авсан өчүүхэн боломжоо алдалгүй тордож явсаар тусгаар тогтнол

³ Жалайр-Дарьхинт Ж.Баатар. *Ил ба далд түрэмгийлэл /Үйл явдал, баримт дурсамж/ УБ хот. 2025 он. 165 дахь тал.*

⁴ Дугарсүрэнгийн Энхцэцэг. *Монголчуудын түүх. /XIV зууны II хагасаас XVII зуун/. УБ хот. 2022 он. 408 дахь тал.*

гэсэн гол зорилгодоо хүрсэн. Эдгээр үе үеийн эх орончдоос Чойбалсанг эс тооцвол бусад нь бараг бүгдээрээ эрхэм үйлсийн төлөө амиа зольсон гэж хэлж болно. Чойбалсан ч гэсэн хойшоо эмчилгээнд яваад бас л учир битүүлгээр нас барсан.

1937 оны хэлмэгдүүлэлт манай түүхэнд том хар толбо болж үлдсэн. Хэлмэгдүүлэлтээр манай 20-25 мянган лам хувраг дээрээс нь шилдэг сэхээтнүүд үрэгдсэн. Гэтэл энэ бол зөвхөн манайд болж өнгөрсөн процесс биш. Тухайн үеийн олон улсын байдал, геополитикийн орчин маш их хүндэрч, дэлхийн дайны босгон дээр тулж ирсэн цаг үе байв. Энэ үед зөвлөлтөд олон арван сая хүн, бүр ард түмнээрээ хэлмэгдэж Сибирь рүү гулагт цөллөг илгээгдэх буюу цаазаар авхуулж байлаа. Украйнд гэхэд зохион байгуулалттай томоохон өлсгөлөн нүүрлэж, хүн амынх нь дөрөвний нэг нь үрэгдэж байв. Туркт армянуудын эсрэг чиглэсэн томоохон геноцид болсон. Гэтэл монголчууд бид ямар нэгэн байдлаар тусгаар оршиж байсан тул хэн ч, тэр тусмаа Сталин хүртэл хэт дураараа аашилж зүрхлээгүй. Үүний нэг жишээ нь 1932 оны зэвсэгт бослогын үеэр асуудал хүндэрч, зөвлөлтийн талаас цэрэг оруулах асуудал сөхөгдөхөд, Сталин эрс няцааж, “Монгол бол манай дотоодын халимаг, буриад биш. Хэрэв бослого дарах цэрэг оруулбал гаднын улсууд биднийг шууд түрэмгийлэл гэж харна. Иймээс аядуу зөөлөн бодлого түр баримталж, буруутан этгээдийг олж тогтоо” гэж үүрэг даалгавар өгсөн нь түүхэн баримт болон үлджээ.

1917 оны хувьсгал болон түүний дараа үүссэн иргэний дайны дараа Зөвлөлт засаг маш хүнд байдалд орсон юм. Эдийн засаг нь бүхэлдээ нурж, үйлдвэрүүд нь зогсон, бараа таваарын болон хүнсний барааны өлсгөлөн ноёрхож байлаа. Үүнд дээр нэмэгдээд Засгийн газрын бодлого нь Зөвлөлт улсыг улс төрийн бүрэн хязгаарлалтад оруулсан бөгөөд тэр нь эдийн засгийн байдлыг бүр ч дордуулсан юм. Угаасаа баруун Европыг бодвол аж үйлдвэр олигтой хөгжөөгүй, ажилчин анги гэж үндсэндээ байхгүй ХАА орныг удахгүй сүйрэн унахыг өрнөдийн орнууд зөвхөн цаг хугацааны асуудал гэж харж байсан нь үнэн. Энэ нөхцөлд зөвлөлтийн дээд эрхийг авсан Сталинд тэсэж үлдэх тэр тусмаа аж үйлдвэрээ асар богино хугацаанд босгохоос өөр зам үлдээгүй. Үүнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ. Чанд хатуу бодлого, төмөр мэт сахилга батаар. Дээрээс нь АНУ тэргүүтэй өрнийн орнуудаас дэвшилтэт техник технологи, аж үйлдвэрийн бааз суурийг худалдан авах ёстой. Мөнгөөр. Тэр мөнгө тухайн үеийн нударган баячуул, язгууртнууд, жижиг хөрөнгөтөн хэмээгдэгч тариачдад байсан. Ингээд Сталины чанд хатуу бодлогын дүнд өчигдрийн тариачин байсан, газраа хураалгасан тариачид хот суурин газарт үйлдвэрийн ажилчин болохоор шилжин ирж, өрснийх нь өмч хөрөнгө, газар, үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин техник болон зүсээ хувиргасан түүхтэй. Өчигдрийн тариачин байсан шинэ ажилчныг үнэтэй машин техниктэй зөв харьцаж сургахын тулд бас л хатуу чанд дүрэм журам тогтоосон. “Үйлдвэрийн машин техникийг эвдвэл буудан ална”. Зөвлөлтүүд дэлхийн 1-р дайнд ялагдсан германчуудтай ч аж үйлдвэрээ сэргээхийн тулд ил далдаар- идэвхтэй хамтран ажилласан байдаг. Маш их нууцлалтайгаар германы үйлдвэр хөгжсөн газруудаас Гамбург, Ростоккийн боомтууд руу аж үйлдвэрийн тоног төхөөрөмж болон зарим нэгэн төрлийн түүхий эд ачсан галт тэрэгний цуваанууд цувж

эхэлсэн. Тэнд бас зөвлөлт орост ажиллахыг зөвшөөрсөн инженер техникчид болон өндөр мэргэжлийн ажилчид цугларч байв. Ингээд 20 хүрэхгүй жилийн дотор дэлхийн 2-р дайн эхлэх үед ЗХУ аж үйлдвэрийн хүчирхэг гүрэн болж танк, их буу, онгоцоо өөрснөө үйлдвэрлэдэг болсон байлаа. Нэг үгээр хэлэхэд Сталины харгис хатуу бодлого Зөвлөлт гүрнийг хөл дээрээ босож, тэсэж үлдэхэд чиглэжээ.

Манай улсад 1937 онд болсон хэлмэгдүүлэлт нь том зургаараа харахад зөвлөлтийн нөлөөний бүсэд хамаарахын хувьд, тусгаар тогтнохын тэмцлийн явцад тохиолдсон эрсдэл⁵ байжээ. Харьцуулбал хятадад өрнөсөн Мао Цэдүний соёлын хувьсгалын хийрхлийн хөлд 2 сая гаран өвөр монголчууд хэлмэгдэж хохирон, өөрсдийн төрсөн өссөн нутаг дээрээ үндэсний цөөнх болж, дарлан хавчигдаж, хагас сая хүн амь үрэгдсэн. Гэвч өвөр монголчуудыг үндэстнийх нь хувьд хамгаалах өөрийн засаг төр байхгүй бүх эрх мэдлийг хятадуудын гарт алдсан байсан тул тэдний хайр найргүй гэгсгээлт засаглал дор хувь заяатайгаа эвлэрэхээс аргагүй байдалтай байжээ. Тухайн үед Монгол Улс 700 мянган хүнтэй байсан гэж үзвэл 30:1, Өвөр Монголыг 6 сая хүнтэй байсан гэж үзэхэд 3:1. Насанд хүрсэн бүх хүмүүс өртсөн гэсэн үг. Өөрөөр хэлбэл монголд явуулсан Сталины хэлмэгдүүлэлт⁶ японтой нийлүүлэхээс сэргийлж, сэхээтэн лам зэрэг тодорхой анги давхарга руу чиглэсэн ажиллагаа байсан бол хятадуудын соёлын хувьсгалаар далимдуулан Өвөр Монголд явуулсан хэлмэгдүүлэлт⁷ нь монгол хүнийг үндэс угсааных нь хувьд бүрмөсөн дарж уусган доройтуулах гэсэн хятадын төрийн уламжлалт бодлого б он/ айснаараа ялгаатай.

Зөвлөлтийн эх орны дайны үед монголчууд өөрийн хир хэмжээнээс давсан их тусламж дэмжлэгийг үзүүлж байсан. Үүн дотор дулаан нэхий дээл хувцас, агт морьд, бүхэл бүтэн танкын хороо, нисэх онгоцны эскадриль зэргийг дурдаж болно. Дайны эхэн үед герман зөвлөлтийн Европт хамаарах дийлэнх хэсгийг эрхшээлдээ оруулж, ердийн хөсөг болон агт морины тоогоор илүүрхэж байхад монголоос нийлүүлсэн хагас сая морь энэ орон зайг хангалттай нөхсөн байдаг. Мөн чөлөөлөх дайнд ч гэсэн ардын армия японы эсрэг оролцуулсан. Энэ бүхэн бол манай үе үеийн эх орончид тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхийн тулд өөрөөс шалтгаалах бүхнийг хийж байсны баталгаа. Гэхдээ энэ хангалттай биш ЗХУ алс дорнодоо хятад эсвэл японоос хамгаалахад монгол тусгаар байх нь жийргэвч бүс тогтоох чухал ач холбогдолтой байсан. Ингээд ялтгын уулзалтаар энэ санаагаа Сталин АНУ Английн талаар хүлээн зөвшөөрүүлсэн. Дараагийн чухал алхам бол Цэдэнбал даргын үед өмнөд хилийг хятадын талтай хамтран нарийвчлан тогтоож, ямар нэгэн маргаан гарахгүй болгож, НҮБ-ээр батлууулж, олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүнээр элссэн явдал юм. Өөрөөр хэлбэл бидний өвөг дээдэс ХХ зуунд хамгийн хүнд хэцүү даалгавруудыг гүйцэтгэж 1.5 сая кв нутагтаа эзэн байх бүрэн эрхт

⁵ ТЕГ-ын Тусгай архив. ДЯЯ-ны гүйцэтгэх харууцлагатай удирдах ажилтны зөвлөгөөний материал./Баримтын эмхэтгэл/ УБ хот. 2024 он. 8 дахь тал.

⁶ Д.Зоригт, Д.Гантөмөр. ОХУ-ын ХАБА-ын архив дахь Монголын талаарх баримтууд./1922-1936 он/ УБ хот. 1925 он. 7 дахь тал

⁷ Жалайр-Дарьхинт Ж.Баатар. Ил ба далд түрэмгийлэл /Үйл явдал, баримт дурсамж/ УБ хот. 2025 он. 484 дэх тал.

тусгаар тогтносон улсыг бидэнд хүлээлгэн өгсөн. Дэлхий дээр күрд, палестинээс өгсүүлээд олон арван сая хүнтэй хинээ тусгаар улсаа байгуулж чадаагүй өчнөөн үндэстэн бусад улсын эрхшээлд буюу олон хэсэг таслагдан оршиж байгаа бэлхнээ жишээ хангалттай байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд, “Үндэсний түүх, хэл соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний орших тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн” гэж заасан. Чухамхүү даяаршлын сөрөг үр дагавраас хамгаалах үндэсний дархлаа бий болгоход зайлшгүй чухал хүчин зүйл нь эх оронч үндэсний үзэл, хүмүүжил юм. Бид бүхэн наадам, цагаан сараар ёс заншлаа дээдлэн, идээ шүүсээ зэхэж, монгол үндэсний дээл хувцсаа өмсөн, хөөрөг даалингаа зөрүүлж, ердийн үеийн биш бүтэн сайхан мэндээр мэндэлдэг. Энэ бол бидний монгол хүн болж төрсний хамгийн том утга учир бахархлыг илэрхийлсэн баярууд. Биднээс үндэсний хэл соёлыг минь авчихвал бид дэлхийн бусад олон зуун ард түмнээс юугаараа ч ялгарахгүй болж, цаг хугацааны аясаар уусаж алга болно. Гэтэл эдүгээ үндэсний язгуур эрх ашгийн эрхэм үнэт зүйл болсон эх оронч үндэсний үзэл, хүмүүжил сулрах, бүдгэрэх аюул учирч буйг цөөнгүй баримт харуулж байна.

Төсөрхөн явуулсан нэгэн судалгаагаар “Сүүлийн жилүүдэд монголын залуу үеийнхний дунд гадаадын улс орон, харийг шүтэх явдал газар авч байгаа гэдэгтэй судалгаанд хамрагдсан 2000 шахам залуучуудын 76.2 хувь нь санал нийлнэ гэсэн бол 23.8 хувь нь санал нийлэхгүй гэж хариулжээ. Ийнхүү олон нийтийн дунд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд гадаад улс орнуудыг шүтэх хандлага нь үндэсний уламжлал, ёс заншлаа үл дээдлэх, эх оронч үзэл тэмүүлэл алдагдах нэг шалтгаан болж байна. Дээрээс нь гадаад орчноос манай үндэсний ахуй соёл, түүх рүү увайгүй дайрах явдал идэвхэжсэн. Тухайлбал, сошиал орчинд хятадаар ярьсан монгол дээл хувцастай хүмүүс монголын малчны ахуй амьдрал, хоол унд хийж байгаа байдлыг харуулсан контентууд их гаргах болсон. Үүнийг хэл ус мэдэхгүй гадаадынхан үзээд монголчууд чинь хятадууд юм байна. Тэдний ахуй соёлын нэг хэсэг юм байна гэж ойлгогдоно. Мөн Чингис хаанаас эхлэн Их Монгол Улсын хаад Юань улсын хаадыг ч өөрийн хаадад оруулан дүрслэх болсон. Тэгсэн хэр нь Ил хаад, Алтан Орд болон Цагаадайн улсын хаадыг оруулахгүй тэр хэдийг л тастаж авдаг. Энэ нь монголчуудыг түүхтэй нь хамт өөртөө өмчлөх алс хэтийн санаа юм. Мөн Казакстанд Чингис хаан болон алтан ургийнхан гэдэг бол казахууд байсан. Монголын эзэнт гүрэн гэдэг бол Казахуудын байгуулсан улс өнөөгийн монголчуудтай ямар хамаагүй гэсэн үзлийг гаргаж, үүнийгээ бататгасан кино зохиол бүтээж, олон улсын ЭШХ хүртэл зохион байгуулах болсон. Казакийн нэгэн судлаач Монголын нууц товчоог казах хэл рүү орчуулахдаа тэнд бичигдсэн уул ус хүний нэрийг зориуд казах нэр томъёогоор сольж өөрчлөх жишээтэй. Туркүүд Хүннүгээс эхлүүлээд Алтан орд Ил хаад бүр Доголон Төмөр гэх мэт монголчуудын, монгол угсаатнуудын байгуулсан эзэнт улсуудыг түркүүдийг байгуулсан улсууд гээд Ерөнхийлөгчийнхөө ордны өмнө тэднийг төлөөлсөн хувцас хэрэглэлтэй хүмүүсийг зогсоодог болсон.

Хэдийгээр эдгээр нь тухайн улсын төрийн болон олон улсын хэмжээнд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй ч гэсэн энэ хандлага цаашдаа маш аюултай.

Үүний эсрэг бид бүхэн түүх соёлоо маш сайн мэддэг, дор хаяж байр сууриа төр засаг, судалгаа эрдэм шинжилгээний байгууллага, иргэний түвшинд хүртэл хамгаалж чаддаг байх хэрэгтэй. Нууц товчоонд дурдагддаг Хэрлэн, Онон, Туул голууд, Тэмүжиний хан бас хаанд өргөмжлөгдсөн Хар Зүрхэний хөх нуур, Хэрлэнгийн Хөдөө арал, Чингис хаанаас дээш 22 үе, өдий хүртэл залгамжилсан Халхын 4 хан хүртэл бүх түүх шастир байгааг дурддаг байх ёстой. Өөрийнхөө түүхийг мэдэхгүй хүнд хэн нэгэн түүхийг нь зохиож өгдөг. Эцэст нь дүгнэхэд тусгаар тогтнол, ахуй соёл гэдэг нь нэг юмны хоёр тал юм. Түүнийг эх орон гэж томъёолдог. Эх орон гэдэг бол ямар ч хүний хувьд хамгийн үнэ цэнтэй зүйл. Хүн ямар ч зовлон зүдүүр туулж хайртай дотно хүмүүсээ алдсан ч эрүүл саруул байвал цаашаа амьдрах учраа олдог. Харин эх орноо алдвал байгаа бүх юмаа алдсантай адил гэдгийг үе үеийн, гадна дотнын эрдэмтэн судлаач, түүхч, яруу найрагч, зохиолчид нэг дуугаар хүлээн зөвшөөрсөн байдаг. Манай нэрт яруу найрагч Пунцагийн Бадарч гуай Монгол туургатны 100 эрхэм нэвтрүүлэгт оролцохдоо “Эх орон гэдэг хэлний үзүүрт биш зүрхний мухарт хадгалагддаг зүйл” гэж хэлж байсан. Ингээд энэ нийтлэлийн агуулгыг магадгүй хамгийн сайн илэрхийлэх 4 мөртөөр дуусгая.

Цэлмэг залуу насныхаа гал дөлөөр бадарч
Сэтгэл зүрх хоёртоо шатаж явах үедээ
Чин итгэлт амрагтаа хэлж үзээгүй үгээ
Чиний төлөө үхнэ гэж зөвхөн эх орондоо тангарагласан
гэж шүлэглэсэн нь ийм учиртай юм аа.

4. Дүгнэлт

Монгол Улсын тусгаар тогтнол нь зүгээр нэг түүхэн тохиолдол бус, харин олон улсын геополитикийн ээдрээт орчин, их гүрнүүдийн ашиг сонирхлын огтлолцол дунд ухаалгаар сонголт хийж, боломжийг зөв ашигласан эх орончдын алсын хараа, тууштай тэмцлийн үр дүн юм. Энэ утгаараа тусгаар тогтнолыг зөвхөн өнгөрсөн үеийн ололт гэж үзэх бус, харин үе үеийн монголчуудын тасралтгүй хамгаалж, бататгаж байх ёстой үнэт зүйл гэж ойлгох нь зүйтэй.

Би тусгаар тогтнолын баталгаа нь дан ганц улс төр, цэрэг, дипломат хүчин зүйлээр хязгаарлагдахгүй гэж үзэж байна. Харин ч үндэсний хэл, соёл, түүхэн ой санамж, уламжлал, эх оронч үзэл зэрэг нь үндэсний дархлааны цөм бөгөөд эдгээр нь сулрах аваас тусгаар тогтнол бодит агуулгаа алдах эрсдэлтэй. Иймээс үндэсний дархлааг бэхжүүлэх асуудлыг соёлын хүрээнд төдийгүй үндэсний аюулгүй байдлын бодлогын төвд авч үзэх шаардлагатай.

Өнөөгийн нөхцөлд даяаршлын нөлөө, гадаад соёлын хэт давамгайлал, түүх соёлын гуйвуулга зэрэг нь монгол үндэстний үнэт зүйлсийг бүдгэрүүлэх хандлагыг бий болгож байна. Үүнийг сөрөн зогсохын тулд бид өөрсдийн түүх, соёлыг гүнзгий танин мэдэж, үндэсний ухамсраа бэхжүүлэн, олон улсын түвшинд өөрийн байр суурийг хамгаалж чаддаг байх нь нэн чухал гэж дүгнэж байна.

Эцэст нь хэлэхэд, тусгаар тогтнол ба үндэсний дархлаа нь салшгүй нэгдмэл ойлголт бөгөөд эх орон гэдэг нь зөвхөн газар нутаг бус, харин түүнийг бүрдүүлэгч хэл, соёл, түүх, үнэт зүйлсийн цогц мөн. Иймд бид эдгээрийг хадгалж хамгаалах нь ирээдүй хойч үедээ тусгаар тогтносон Монгол Улсыг бүрэн бүтэн өвлүүлэн үлдээх үндсэн нөхцөл юм

5. Эх сурвалж

- Жалайр-Дарьхинт Ж.Баатар. *Ил ба далд түрэмгийлэл /Үйл явдал, баримт дурсамж/ УБ хот. 2025 он.*
- Дугарсүрэнгийн Энхцэцэг. *Монголчуудын түүх. /XIV зууны II хагасаас XVII зуун/. УБ хот. 2022 он.*
- П.Дэлгэржаргал, Б.Чинзориг, Ж.Болдбаатар. *Монгол Улсын түүх. УБ хот. 2017 он.*
- ТЕГ-ын Тусгай архив. *ДЯЯ-ны гүйцэтгэх хариуцлагатай удирдах ажилтны зөвлөгөөний материал./Баримтын эмхэтгэл/ УБ хот.*
- Д.Зоригт, Д.Гантөмөр. *ОХУ-ын ХАБА-ын архив дахь Монголын талаарх баримтууд./1922-1936 он/ УБ хот. 1925 он.*